

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пүрэвсүрэн	Дугаар	L211
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Өндөрхангай сум
Төрсөн газар	Өндөрхангай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Хийдийн тэргүүн		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Одоогийн сүм хийд	Гандандаржаалин хийд	Сүм хийдийн дугаар	УВӨХ 017
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 6-р сарын 4	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

### Увс аймгийн Өндөрхангай сумын Гандандаржаалин хийд

Билэг-Өрнөх:Увс аймгийн Өндөрхангай сумын Гандандаржаалин хийдийн тэргүүн Пүрэвсүрэн гуайтай уулзаж байна аа.

Пүрэвсүрэн: Бурхны шашин дэлгэрэх үйлсэд ерэн оноос хойш зүтгэж байна аа. За энд хоёр гурван газрыг хурал ном хийдтэй болгоод, гурван ч газар есөн суварга бүтээлээ. Бурхан суварга өөрийн гараар бүтээчихдэг болохоор бас санасан бодсон болгон бас бүтээд байдаг юм аа. Ерэн онд 19 өвгөн ламтай хурал эхэлж байлаа. Одоо нэг 8 ламтай байх шив дээ. Гандантэгчинлэн хийд рүү явуулж бас нэлээн хүүхэд сургасан. Тэд нар маань тэгээд хурлаа хурдаг .Би өөрөө болохоор ном ч байхгүй. Гэхдээ ууланд гурван жил байрлан сууж тарни бясалгасан. 1938 онд хаагдсан юм байна лээ. Байгуулагдсан оноо хойш хуучин 190 жил оршин тогтноод тэгээд тарцгаасан юм гэнэ лээ. 600 гаруй ламтай байсан юм гэсэн. Тэгээд хэлмэгдүүлэлтийн үед сүм дуганыг нь нураагаад, лам нарыг нь баривчлаад тэгээд сүйрүүлчихсэн. Лам дутагдах янзтай юм аа. Гандан, Гэсрийн сүмээс манайд их тусалдаг. Бид нар энчээ байнга холбоотой байдаг.Энэ нутгийн лам нар байдаг юм л даа.24 суварга бүтээх санаатай, нэг хоёр томхон сахиус бүтээх санаатай бэлтгэл хийгээд л байна. Одоо хийдийн арван жилийн ой болно. Тэрийг угтаж бас дутуу бүхнээ гүйцээх санаатай л зүтгэж байна даа.